



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/А95

Булган сум

┌ Ажил, амралтын цагийг зохицуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажил, амралтын цагийг зохицуулах зорилгоор 2025 оны 07 дугаар сарын 11-ний нийтээр тэмдэглэх баярын өдрөөр аймгийн баяр наадмын зохион байгуулалтад ажилласан төрийн албан хаагчдыг 2025 оны 07 дугаар сарын 18-ны Баасан гарагт нөхөн амраасугай.

2. Ажилтны ажил амралтын цагийг зохицуулах арга хэмжээ авч, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт төрийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР